



## **Нээлттэй Нийгэм Форум**

**«УЛСЫН ТӨСВИЙН  
ҮЙЛ ЯВЦ, 2004 ОНЫ  
ТӨСВИЙН ОНЦЛОГ»  
СЭДЭВТ УУЛЗАЛТ  
ЯРИЛЦЛАГЫН  
ХӨТӨЛБӨР**

**«Чингис» зочид буудал  
2004 оны 1-р сарын  
15-ны өдөр**



**МОНГОЛ УЛСЫН 2004  
ОНЫ ТӨСВИЙН  
ОНЦЛОГ,  
Е РӨНХИЙ ЧИГ  
ХАНДЛАГА**



### **Зорилго**

(1) Улсын төсөв боловсруулах, хэлэлцэх, батлах, хэрэгжүүлэх бүхий л үе шатад иргэдийн оролцоо ямар байх, (2) 2004 оны Улсын Төсвийн зарчмын онцлог (макро чиг хандлага) сэдвээр сонирхогч талууд хамтран хэлэлцэх болно.



### **Уулзалтын хэлбэр**

Уулзалт ярилцлагыг панел хэлбэрээр явуулах бөгөөд Улсын Их Хурал, Засгийн Газар, хандивлагчдыг төлөөлсөн 6 хүний бүрэлдэхүүнтэй байх юм. Уулзалтад төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээлэл, бизнесийн төлөөлөл, тэрчлэн хандивлагчид уригдан оролцож санал бодлоо илэрхийлэх боломжоор хангдах болно.



### **Панелийн бүрэлдэхүүн**

1. Ч. Улаан, УИХ-ын гишүүн, Санхүү, эдийн засгийн сайд
2. Д. Цэвээнжав, УИХ-ын гишүүн, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга
3. Доун Рэм, Олон улсын валютын сангийн суурин төлөөлөгч
4. Саха Мсаянатан, Дэлхийн банкны суурин төлөөлөгч
5. Барри Хичхок, Азийн хөгжлийн банкны суурин төлөөлөгч

#### **Хөтөлбөгч:**

Д. Энхбат, Датаком ХХК-ий Ерөнхий Захирал

#### **Хөтөлбөр:**

- |               |   |
|---------------|---|
| 16.00 – 16.10 | Уулзалтыг нээх, МННХ-ийн Удирдах Зөвлөлийн гишүүн Д.Жаргалсайхан                    |
| 16.10 – 16.17 | УИХ-н гишүүн Н. Цэвээнжав «Төсвийн үйл явц ба иргэдийн оролцоо»                     |
| 16.17 – 16.40 | Панел хэлэлцүүлэг   |
| 16.40 – 17.00 | Оролцогчдын асуулт, санал шүүмж   |
| 17.00 – 17.07 | Санхүү, эдийн засгийн сайд Ч. Улаан «2004 оны төсвийн онцлог, ерөнхий чиг хандлага» |
| 17.07 – 17.35 | Панел хэлэлцүүлэг   |
| 17.35 – 17.55 | Оролцогчдын асуулт, санал шүүмж   |
| 17.55 – 18.00 | Хэлэлцүүлгийг хаах, хөтлөгч Д. Энхбат   |



**Илтгэгч: Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан**

**МОНГОЛ УЛСЫН 2004 ОНЫ ТӨСВИЙН ОНЦЛОГ, ЕРӨНХИЙ ЧИГ ХАНДЛАГА**

**Эрхэм ноход өө,**

“Нээлттэй нийгэм форум”-аас санаачлан зохион байгуулж байгаа “Улсын төсвийн үйл явц, 2004 оны төсвийн онцлог “сэдэвт энэхүү ярилцлагад оролцогч та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүль. Энэхүү ярилцлага нь нээлттэй засаглалыг хөгжүүлж, бэхжүүлэх, төсвийн ил тод байдлыг хангаж, ард иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа бодлого, чиглэл, үйл ажиллаганд тодорхой хувь нэмэр оруулахуйц үр дүнтэй, ажил хэрэгч ярилцлага болно гэдэгт найдаж байна.

Ингээд бидэнд ирүүлсэн санал, урилгын дагуу Монгол Улсын 2004 оны төсвийн онцлог болон улсын төсвийн талаарх мэдээлэл түгээлтийн өнөөгийн байдлын талаар та бүхэнд товч мэдээль.

#### **Нэг. Монгол Улсын 2004 оны төсвийн тухай хууль, төсвийн онцлогийн талаар**

Монгол Улсын Засгийн газар “Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль” - “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль”-ийг үндэслэн 2004 оны төсвийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд хуулийн хугацаанд өргөн барьсан билээ.

Засгийн газар 2004 оны төсвийг зохиохдоо УИХ-аас зөвшөөрөгдсөн “Төсвийн хүрээний мэдэгдэл”-ээр тодорхойлсон эдийн засаг, нийгмийн хөгжил, төсвийн

тэнцвэрийн макро үзүүлэлтүүд болон УИХ-аас өгөгдсөн чиглэл, УИХ-ын эрхэм гишүүдээс гаргасан санал, зөвлөмжийг харгалзан үзэж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан зорилтуудыг төсвийн талаас бүрэн хангах, дунд хугацаанд улсын эдийн засаг, нийгмийн хөгжил, санхүү-төсвийн зохистой тэнцвэрт харьцааг хадгалах зарчим баримтлав. Энэ зарчмыг баримтлаадаа бий болсон нөхцөл байдал, энэ онд хүрэх түвшин, нааштай хандлагыг батжуулах замаар дотоод нөөц боломжоо илүүтэй шавхан дайчлах, дунд хугацаанд тодорхойлсон зорилтоо бүрэн биселүүлэх, асуудалд бодитой хандаж төсөвлөлтийн чанарыг сайжруулахад онцгой анхаарал хандуулсан.

Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийг 2004 онд төсвийн хүрээний мэдэгдэлд тусгаснаас 0.7 пунктээр нэмэгдүүлэх, улсын төсвийн нийт алдагдлын ДНБ-нд эздэх хувийг 5.9 хувиас хэтрүүлэхгүй байлгах тэнцвэрийг хангах үндсэн дээр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасны дагуу хүн амын татварын дарамтыг бууруулах, төрийн албанд ажиллагсдын цалин хөлс, нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, нийгмийн эмзэг бүлгийг ядуурлаас сэргийлж, өрхийн амьжиргаанд төрөөс дэмжлэг үзүүлэх боломжийг зарчмыг баримталсан юм.

Боловсрол, эрүүл мэндийн зэрэг нийгмийн салбаруудын хөгжлийг хангах, улс орны дэд бүтцийг хөгжүүлэх, түүний дотор хөдөө орон нутгийн цахилгаан эрчим хүчиний хангамжийг сайжруулах, зам, гүүрийн барилга байгууламжийг барих, сургууль, эмнэлэг, сёёлын байгууллагын засвар үйлчилгээг төсвийн санхүүжилтээр дэмжихийн зэрэгцээ төсвийн удирдлагын шинэчлэл, бүтцийн өөрчлөлтийг явуулах, төрийн албаны ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлэх ажлыг эрчимжүүлж түүний үр дүнгээр бий болох нэмэгдэл боломжийг дайчлан ашиглаад онцгой анхаарсан болно.

Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилтын 2003 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан бодлогын зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явцад дүн шинжилгээ хийж, дунд хугацааны бодлогын зорилт, стратегитай нягт уялдууллаа.

Энэ жил бол манай Засгийн газрын бүрэн өрхийн хугацааны барианы жил учир 2000 оноос хойш хэрэгжүүлсэн бодлого, зорилт, арга хэмжээнүүдийг дуусган, хүрсэн үр дүн, ололт өөрчлөлтийг дүгнэх хариуцлагатай жил байх болно гэдгийг ч харгалзан үзсэн юм.

Сүүлийн жилүүдэд эдийн засагт сэргэлт бий болж, үндсэн үзүүлэлтүүд тогтвожиж байгаа бөгөөд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “*Эдийн засаг, төсөв, санхүүгийн тогтолцоог эрүүрэжсүүлж эдийн засгийн цаашдын өсөлтийн үндэс суурийг тавина*” гэсэн зорилт бүрэн хангагдахаар байна.

Татвар төлөгчдөөс төрийн мэдэлд цүглуулсан хөрөнгийг үр дүнтэй зарцуулах, ил тод хяналттай байлгахад Засгийн газар онцгой анхаарал хандуулж ДНБ-ний болон орлогын өсөлтөөс зардлын өсөлтийг түрүүлүүлэхгүй байлгах зарчим баримталж байна.

Онгөрсөн 2003 оноос эхлэн төсвийн хариуцлагын шинэ тогтолцоог бүрдүүлэхэд чиглэгдсэн “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль”-ийг дагаж мөрдөж эхэлснээр урьд нь байгууллагын гарсан зардал, орон тоог санхүүжүүлдэг байсан арга зүйн хуучин тогтолцоо халагдаж байгууллага, нэгжийн бүтээгдэхүүн, хүрсэн үр дүнг санхүүжүүлдэг болсноор зөвхөн зарцуулсан хөрөнгийн дүнг бус төсвийн буюу татвар төлөгчдийн хөрөнгийг чухам ямар зорилгоор, юунд зориулан зарцуулж байгааг төсвийн захирагч нэг бүрээр тодорхой тайлагнах боломжтой болж байна.

Энэ зарчмыг иш үндэс болгон ирэх жилийн санхүүжилтийн хэмжээг тодорхойлоходоо дараах асуудалд анхаарал төвлөрүүлсэн юм.

- ◆ “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг гүнзгийрүүлж, төсвийн байгууллага, нэгжүүдийн нийлүүлэх бүтээгдэхүүний захиалга, гэрээг үндэслэх;
- ◆ Төрийн албаны шинэчлэл, бүтцийн өөрчлөлтийг эрчимтэй явуулж төрийн албаны чадавхийг сайжруулж цомхон, чадварлаг бүтэц бүрдүүлэх, төрийн үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх;
- ◆ Нийгмийн салбарын хувьчлал, өөрчлөн байгуулалтыг эрчимжүүлж арилжааны горимоор ажиллах боломжийг нээх, төрийн ачаалал, оролцоог бууруулах;
- ◆ Төрийн албанад ажиллагсдын цалин хөлс, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тэтгэврийг нэмэгдүүлэх эх үүсвэрийг бодитойгоор бүрдүүлэх, шинэчлэл, бүтцийн өөрчлөлтийн бодит үр дүн, инфляци, үнэ ханшийн өөрчлөлттэй уялдуулан цалин, тэтгэврийг үе шаттайгаар нэмэгдүүлэх;

Гэвч эдийн засагт төсвийн зардлын хувийн жин нилээд өндөр байгаа нь цаашид эдийн засгийн болон нийгмийн салбар, төрийн захираганы бүтэц тогтолцоо, бусийн хөгжлийн стратегитэй уялдуулсан бүтцийн өөрчлөлт, шинэчлэл хийх шаардлага байсаар байгааг харуулж байна.

Энэ байдалд дүгнэлт хийж ДНБ-нд төсвийн нийт зардлын эзлэх хувийн жингийн өсөлтөөс ургал зардлын хувийн жингийн өсөлт түрүүлэхгүй байх тэнцвэрийг хадгалах зарчмыг хатуу баримтлан ажиллаж байна.

Засгийн газраас санал болгосон 2004 оны төсвийн зарлагын үзүүлэлт нь Монгол улсын төсвийн дунд хугацааны тогтвортой байдал сайжрах, УИХ-аас зөвшөөрсөн төсвийн хүрээ болон ОУВС-тай ЯБОХ хөтөлберийн хүрээнд тохиролцсон шалгуур үзүүлэлтүүд, төрийн албаны шинэчлэлийн дунд хугацааны хөтөлбөр, Дэлхийн банктай явуулж байгаа хэлэлцээрүүдийн явцад тавьж байгаа шаардлагуудыг үндсэнд нь хангаж байгаа юм.

**Төрийн албанад ажиллагсдын цалингийн өсөлтийн талаар 2001-2004 онд тавьсан зорилтыг эдийн засгийн өсөлт, төрийн албаны шинэчлэл, салбаруудын, түүний дотор нийгмийн салбарын бүтцийн өөрчлөн байгуулалтын үр дунд тулгуурлан шийдвэрлэх зарчим баримтлаж байна.**

Энэ онд бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээ, цалингийн батлагдсан сандaa багтааж төсвийн ерөнхийлөн захирагчид “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль”-ийн дагуу салбарынхаа ажиллагсадад олгох цалинг тогтоож мөрдүүлэх журмыг хэрэгжүүлнэ. 2004 онд улсын төсвөөс санхүүжүүлэх цалин хөлсний зардал 129.0 тэрбум төгрөг байгаа бөгөөд энэ нь манай Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд хоёр дахин нэмэгдсэн үзүүлэлт юм.

Төрийн албан хаагчдын цалингийн сан ингэж нэмэгдсэн байгааг үндэслэн төсвийн эрх захирагчид ажилтан, албан хаагчдынхаа цалин бүтцийн өөрчлөлт, үйл ажиллагааны үр дүнтэй холбон ялгавартайгаар тогтоох учиртай бөгөөд энэ нь 2000 оны эхэнтэй харьцуулахад хамгийн багаар бодоход хоёр дахинаас илүү нэмэгдсэн байх болно.

Төрийн албанад болон төсвийн байгууллагад ажиллагсад улсын хэмжээний нийт хөдөлмөр эрхлэгчдийн 17 орчим хувийг эзэлж байна. Манай эдийн засагт төсөвт байгууллагын цалин хөлсний зардлын эзлэх хувь хэмжээг дэлхийн улс орнуудынхаас харьцангуй өндөр байгаа бөгөөд энэ агуулгаараа эдийн засагт төрийн оролцоо их, төрийн албаны бүтэц тогтолцоо төгс бус, зардал ихээхэн өндөр байна гэж шүүмжлэгддэг.

Ийм учраас цалин хөлсийг өсгөхийн сапуу төрийн албыг улам чадваржуулах, ДНБ-нд эзлэх төсвийн зардлыг, түүний дотор цалингийн үнэмлэхүй хэмжээг бууруулах асуудлыг төрийн захирагааны тогтолцоо, бүтцийн өөрчлөлт, шинэчлэл, нийгмийн салбарын өөрчлөн байгуулалтын хүрээнд дэс дараатай шийдвэрлэх зорилт тавьж байна.

Ийнхүү дээр дурьдсан зарчим, зорилтын дагуу боловсруулагдан батлагдсан төсвийг зориулалтын нь дагуу, цаг хугацаанд нь санхүүжүүлэх, төсвийн орлогоо төлөвлөгдсөн хэмжээнээс багагүйгээр бүрдүүлэх, төсвийн хуулийг хэрэгжүүлэх ажил энэ оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд цаашид бидний өмнө асар их үүрэг хариуцлага, зорилт өдөр тутам хүлээгдэж байна.

### **Хоёр. Улсын төсвийн мэдээлэл түгээлт, сурталчилгааны өнөөгийн байдлын талаар**

Мэдээллийг дутмаг байдал, бүрэн нээлттэй орчин нь нэг талаар хээл хахуул бий болох орчныг бүрдүүлдэг, нөгөө талаар ард иргэдийн дунд бүрхэг таамаглал, буруу ташаа ойлголтыг төрүүлэх, тархаах орчин болж байдаг тул төрийн байгууллагуудын зүгээс үйл ажиллагааныхаа талаарх мэдээллийг хүртээмжтэй болгох, ил тод байлгах явдал нь өргөн утгаараа асар их ач холбогдолтой гэж үзэж байна.

Жил бүрийн төсвийн төслийг боловсруулах явцад төсвөөс санхүүждэг, хувь хүртдэг бүхий л шатны төсөвт байгууллагууд, олон нийтийн байгууллагууд, нийгмийн даатгалын болон халамжийн сан зэрэг байгууллага, албан газрууд нь Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 26 -30 дугаар зүйлүүдэд заасны дагуу ирэх онд гүйцэтгэх ажил үйлчилгээ, түүнд шаардагдах төсөв хөрөнгийн хэрэгцээнийхээ талаар нэг бүрчлэн саналаа ирүүлж, тэдгээр саналыг санхүүгийн байгууллагууд хянаж, нягтласны дараа төсвийн төсөлд тусгадаг.

Батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийг сурталчиллах талаар өнөөгийн харилцаа холбоо, мэдээллийн хэрэгслэлийн боломж нь дараах байдалтай байна. Үүнд:

Нэгд. Нийт улс орон даяар тархах боломжтой буюу хамгийн хүртээмжтэй мэдээллийн сувгууд нь Монголын радиогийн суваг, Үндэсний телевизийн суваг, өдөр тутмын сонинууд, Төрийн мэдээлэл сэтгүүл, нийтийн номын сангуд юм.

Хоёрт. Нийслэл, Дархан, Орхон хот, Төв аймгийн төв, төмөр замын дагуух томоохон суурин газрууд зэрэг техникийн нөхцөл боломж харьцангуй сайн бүрдсэн, мэдээллийн эх сурвалж, станцууд төвлөрсөн газруудад дээрх мэдээллийн сувгуудаас гадна богино долгионы радио, интернэт мэдээллийн төвүүд, орон нутгийн телевиз, радиогийн сувгийг ашиглан мэдээллийг харьцангуй хүртээмж сайтай, шуурхай түгээх боломжтой байна.

Хэдийгээр Санхүү эдийн засгийн яам болон төрийн захиргааны бусад төв байгууллагуудаас төрөл бүрийн гарын авалга, товхимол хэвлэн нийтэд түгээж байгаа боловч хэвлэлийн зардал, орон нутагт хүргэх тээврийн зардал зэргээс шалтгаалж аймгийн төвөөс цааш нийт сумд, багуудад хүртээмжтэй, тогтмол түгээх боломжгүй байна.

Орчин үеийн холбоо, мэдээллийн давуу талд тулгуурласан Засгийн газрын “Open – government” вэб хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчиллах, түгээх боломжтой боловч интернэтэд холбогдох боломжтой, түүнийг байнгын хэрэглээ болгосон иргэдийн тоо цөөн, тэдгээр нь үндсэндээ Улаанбаатарт болон гадаад улс орнуудад оршин сууж байгаа иргэд байгаа юм. Интернэтээр дамжуулан түгээх сурталчилгаа нь гол төлөв төрийн албан хаагчид, оюутан залуучууд, аж ахуйн нэгж байгууллагын удирдах албан тушаалтнуудын хүрээнээс төдийлөн хэтрэхгүй, хөдөө орон нутгийн иргэдийн байнгын хэрэглээ болж чадаагүй байна.

Иймээс цаашид улсын төсвийн гүйцэтгэл, төсвийн төслийн талаарх мэдээлэл сурталчилгааг явуулахад ойрын жилүүдэд вэб хуудаснаас гадна уламжлалт ном товхимол, гарын авлага, өдөр тутмын хэвлэлийг ашиглах нь мэдээлэл түгээх үндсэн арга хэрэгсэл байсаар байх болов уу гэж үзэж байна.

Онөөгийн байдлаар УИХ-ын тамгын газрын төсөвт “Төрийн мэдээлэл” сэтгүүлийг хэвлэх түгээх зардал, СЭЗЯ-ны төсөвт зарим нэр төрлийн ном товхимол хэвлэх зардал, Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсөвт Монгол улсын хууль тогтоомжийг сурталчиллах зэрэг тодорхой хэмжээний зарлыг тусган, хэрэгжүүлж байгаа боловч энэхүү хөрөнгийн эх үүсвэр нь Олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагуудын зүгээс мэдээллийн ил тод байдлыг хангах талаар тавьж байгаа санал, зөвлөмжийн дагуу мэдээллийг нийт ард иргэдэд түгээхэд бүрэн хүрэлцэхгүй байгаа нь тодорхой юм.


Иймд өнөөдрийн уулзалт ярилцлагын үр дүнд төсвийг боловсруулах явцад ард иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төсвийн гүйцэтгэл, тайлан, батлагдсан төсвийн талаарх мэдээллийг олон нийтэд сурталчиллах чиглэлээр тодорхой арга зүйн болон хөрөнгө санхүүгийн туслалцаа үзүүлж хамтран ажиллавал бид дуртайяа хүлээн авах болно.

Ярилцлагад оролцож буй Олон улсын байгууллагуудын суурин төлөөлөгчдийн санал, бодлыг сонсож, цаашид ярилцаж буй чиглэлээр хамтран ажиллахад бэлэн байна.


Анхаарал тавьсан явдалд байрлалаа.

## САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ЯАМ

### Монгол улсын төсвийн орлого, зарлагын ДНБ-д эзлэх байр



### Нэгдсэн төсвийн алдагдал ба ДНБ-ний өсөлт




### МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛ


сая төгрөгөөр

	Гол	Гүйцэт.	Хувь		ДНБ-д	
			Заруу		зэлж хувь	
	Төлөв.	(0 : 2)	(0 : 2)		төл	гүйц
(Сая төгрөг)						
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДУН</b>	<b>495,593.7</b>	<b>535,795.7</b>	<b>108.1</b>	<b>40,202.0</b>	<b>36.0</b>	<b>39.4</b>
УРСГАЛ ОРЛОГО	456,803.0	526,368.6	105.1	39,565.6	35.4	38.7
ТАТВАРЫН ОРЛОГО	373,200.1	404,410.6	105.4	31,210.5	27.1	29.7
ТАТВАРЫН БҮС ОРЛОГО	113,603.0	121,958.0	107.4	8,355.0	5.3	9.0
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	590.6	759.0	128.5	168.4	0.0	0.1
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	8,200.0	8,668.1	105.7	468.1	0.6	0.6
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДУН</b>	<b>580,672.0</b>	<b>616,536.9</b>	<b>106.2</b>	<b>35,864.9</b>	<b>42.2</b>	<b>45.3</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	435,357.6	446,278.7	102.5	10,921.1	31.7	32.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	65,090.1	88,819.7	136.5	23,729.7	4.7	6.5
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	80,224.3	81,438.5	101.5	1,214.2	5.8	6.0
УРСГАЛ ТЭНЦЭЛ	51,445.5	60,089.9	155.7	28,644.5	3.7	5.9
<b>НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>-85,078.3</b>	<b>-80,741.2</b>	<b>94.9</b>	<b>4,337.1</b>	<b>-6.2</b>	<b>-5.9</b>


### Монгол улсын урсгал орлого, зарлагын ДНБ-нд эзлэх хувь



### Монгол улсын төсвийн орлого, зарлагын харьцаа



### Төрийн албан хаагчдын дундаж



## Төсвийн үйл явц, түүн дэх иргэдийн оролцоо

Та бүхний энэ өдрийн амар амгаланг эрж мэндчилье.

Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн Нээлттэй Нийгэм Форум хэмээх шинэ хөтөлбөр хэрэгжүүлж эхлээд байгаад талархал илэрхийльс.

Төсвийн үйл явц, түүн дэх иргэдийн оролцоо гэсэн сэдэв нь хууль эрх зүйн хэм хэмжээгээр илэрхийлэгдсэн ойлголт байх болно.

Төсвийн үйл явц гэж чухам юуг ойлгох вэ? гэдгээс эхэльс.

Монгол Улсын төсөв боловсруулахаас эхлээд хуульчлан батлах, төсвийг хэрэгжүүлж эхлэх, төсвийн эрх захирагчид төсвийн гүйцэтгэлийг хэрхэн тайлагнах үйл явцыг авч үнэ. Энэхүү төсвийн үйл явцын циклыд иргэдийн оролцоо ямар байгааг хоёр дахь хэсэгт хөндж ярилцах болно.

Монгол Улсын Их Хурал 2002 оны хаврын чуулганаар Төсвийн тухай хууль батлав. Энэ хуулиар төсөв нь улсын төсөв, орон нутгийн төсвөөс бүрдэх бөгөөд энэ 2 төсвийн нийлбэрийг Монгол Улсын Нэгдсэн төсөв гэж тодорхойлох болсон юм.

Орон нутгийн төсвийг аймаг нийслэлийн ИТХ-аар хэлэлцэн баталж байна.

Монгол Улсын төсөв гэдэг ойлголт нь төсвийн орлого, зарлага гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэж байна.

Орлого нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэж байна.

Зарлага нь улс орон нутгийн төсөвтэй харьцагаа боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, батлан хамгаалах, нийтийн хэв журам сахиулах болон төр захиргаа, гүйцэтгэх засаглалын бүхий л зарлага, санхүүжилт мөн улс орны нийтлэг үйлчилгээний хөрөнгө оруулалтын арга хэмжээг хамруулан авч үзэж байна.

Төсвийн орлого талыг бүрдүүлэхэд улсын татварын албанад бүртгэлтэй аж ахуйн нэгжүүд орлого бүхий иргэд Монгол Улсын татварын хуулийн дагуу оролцож байна.

Төсвийг зарцуулахад төсвийн срөнхийлөн эрх захирагчидийн хүрээнд хамаарах сургууль, эмнэлэг, соёл урлаг, спортын байгууллага, нийгмийн хамгаалалын байгууллагууд, төрийн захиргааны болон тусгай албадууд тэнд ажилласад 120 гаруй мянган хүн оролцож байна.

Төсвийн орлогыг бүрдүүлэхэд татварын албанад бүртгэлтэй аж ахуйн нэгжид нэмүү өртөг бүтээгчидээс гадна Монгол Улсад хөдөлмөр эрхэлж байгаа иргэд, хөрөнгийн орлогоос татвар төлөгч нийтдээ 900 шахам мянган хүн оролцож байна.

Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтын тухай хууль 2002 оны хаврын чуулганаар батлагдаад мөрдөгдөж байна. Энэ хуулиар төсвийн үйл явцыг цаг хугацааны хувьд тодорхой хуульчилж өгсөн байгаа. Ингэж төсвийн үйл явцыг хугацааны хувьд хуульчилсан нь иргэдийн оролцоог сайжруулах, төсөв цэгтэй, ойлгомжтой байх, төр, гүйцэтгэх засаглалын байгууллагуудын хүлээх үүрэг тодорхой болж өгсөн нь их ач холбогдолтой болсон юм.

Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтын тухай хуулийн 25-3-д УИХ төсвийн хүрээний мэдэгдлийг хаврын чуулганаар хэлэлцэж шийдвэрлэнэ гэсэн заалт бий.

2004 оны төсвийг боловсруулахын тулд төсвийн хүрээний мэдэгдлийг нийт яамд төсвийн бусад срөнхийлөн захирагчидтай хамтран боловсруулж ЗГ-аар хэлэлцээд V сард УИХ-д өргөн барьж хэлэлцүүлэв.

2004 оны төсвийн хүрээний мэдэгдлийн гол стратеги нь:

Нэг, Монгол Улсын төсвийн тогтвортой тэнцвэртэй байдлыг олон улсын санхүүгийн байгууллагуудтай урьдчилан тохиролцсон түвшинд байлгаж, төсөв-санхүүгийн дунд хугацааны шинэчлэлийг гүнзгийрүүлэх замаар улсын санхүүгийн тогтолцоонд сүүлийн жилүүдэд бий болсон нааштай өөрчлөлтийг бататгах;

Хоёр, Эдийн засгийн өсөлтийн үр дүнг улсын санхүү, үндэсний хуримтлалыг нэмэгдүүлж, ДНБ-д төсвийн хэрэглээ, зардал түүний дотор урсгал зардлын эзлэх хувийн жинг үе шаттай бууруулах;

Гурав, Төрийн албаны шинэчлэл, бүтцийн өөрчлөлт, түүний дотор улсын үйлдвэрийн газрын хувьчлал, нийгмийн салбарын төсвийн байгууллагуудын өөрчлөн байгуулалтыг эрчимтэй явуулж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг чанаржуулж, хэрэглэгчдэд ойр дот, хүртээмжтэй болгоход төсвийн удирдлагын үр нөлөөг сайжруулахад чиглүүлж байна.

Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтын тухай хуулийн 27.1-д Улсын төсвийн байгууллага өөрийн үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөний төслийг төсвийн срөнхийлөн захирагчид 7-р сарын 1-ний дотор төсвийн срөнхийлөн захирагчид санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллагад 8-р сарын 15-ны өдөр ирүүлнэ.

Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтын хуулийн 31.1-д Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллага нь төсвийн срөнхийлөн захирагч бүрийн төсвийн төслийг нэгтгэж 9-р сарын 15-ны дотор Засгийн Газарт ирүүлнэ.



**НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ  
ФОРУМ-Д  
ТАНИЛЦУУЛАХ МЭДЭЭЛЭЛ**  
★  
**ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦ,  
ТҮҮН ДЭХ  
ИРГЭДИЙН ОРОЛЦОО**

Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтын тухай хуулийн 32.1-д Засгийн Газар 10- сарын 1-ний өмнө улсын төсвийг дараах бичиг баримтын хамт УИХ-д өргөн мэдүүлж байгаа. Үүнд:

- эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл
- улсын төсвийн төсөл
- төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн төсөл УИХ эдгээр баримт бичгийг хүлээж аваад тус хуулийн 32.2-д заасан шалгуураар хянан үзэж байнгын хороодоор хэлэлцүүлж эхэлнэ. Төсвийг 4 үе шаттайгаар хэлэлцэж улсын төсвийг 12-р сарын 1-ний өдрийн өмнө хэлэлцэж баталсан байх хууль үйлчилж байна.

XII сард багтаж яамдын сайд буюу төсвийн ерөнхийлөн захирагчид аймаг нийслэлийн засаг дарга нар болон аймаг нийслэл, сум дүүргийн засаг дарга нар төсвийн ерөнхий менежертэй бүтээгдэхүүн худалдан авах гэрээ байгуулж ажиллаж байна.

Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтын тухай хуулийн 38.1-д Төсвийн гүйцэтгэл болон Засгийн газрын жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 3-р сарын 20-ны дотор аудитын дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын төв байгууллагад хүргүүлнэ.

Төрийн аудитын төв байгууллага нэг сарын дотор дүгнэлт гаргаж өгнө.

Улсын төсвийн байгууллага хагас бүтэн жилээр санхүүгийн тайлан гаргана.

Төсвийн срөнхийлөн захирагч санхүүгийн жилийн эцэст үйл ажиллагааны үр дүн, төсвийн гүйцэтгэл, аудитын дүгнэлтийн хамт Засгийн газрын хуралдаанд танилцуулна.

Засгийн газар төсвийн срөнхийлөн захирагчидын төсвийг нэгтгэж аудитын дүгнэлтийн хамт УИХ-д төсвийн гүйцэтгэлийг батлуулахаар өргөн барьдаг хууль үйлчилж байна.

УИХ төсвийн гүйцэтгэлийг хаврын чуулганаар хэлэлцэж улсын төсвийн гүйцэтгэлийг батална.

Эндээс харахад Монгол Улсын төсвийг боловсруулах, батлах, тайлagnah үйл явц бүтэн жилийн турш байнга үргэлжилдэг болохыг харж болно.

Төсвийн үйл явцыг срөнхийлөн танилцуулбал ийм байна.

Төсвийн үйл явцыг цаг хугацааны хувьд ард иргэд сайн мэдэж байвал оролцох оролцоо сайжрах учиртай. Юуны өмнө төсвийн срөнхий менежерүүд байгууллага хамт олондоо болон танай байгууллагаар үйлчлүүлэгчидэд төсвийнхөө талаар тодорхой ойлголт өгч сурталчилж тэдний санал бодлыг нэгтгэн авч үзэх нь чухал байна. Төсвийн үйл явцад ард иргэд чухам яж оролцож байгааг хоёр талаас нь авч үзье.

Төр олон нийтэд үйл ажиллагаагаа төсвөөр дамжуулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж байгаа. Энэ талаар та бүхэнд товч материал очсон байгаа.

Ард иргэд энэхүү сурталчилгааны үр дүнд улсын төсвийн талаар тодорхой мэдээлэл авч харыцах бололцоо бүрдүүлж байгаа гэж ойлгож болно.

Харин ард иргэдийн оролцоо ямар байна вэ? гэдгийг дараах байдлаар авч үзэж болох юм.

- төсвийн санхүүжилт авч байгаа байгууллагын ажиллагсад (121.0 мянга орчим)
  - төсөв бүрдүүлж байгаа нийт хүмүүс (900.0 мянга орчим)
  - төсвийн үр шимийг тойруу замаар хүртэж байгаа хүмүүс
- гэж ангилж болох юм. Энн сүүлийн бүлэгт эхний хоёр бүлэг хүмүүсийг давхардуулан оруулж тооцвол Монголын нийт хүн ам бараг 100 шахам хувиар хамрагдана гэсэн үг.

Онөөдөр амьдрал дээр төсвийн үйл явцад төрийн тусгай болон төрийн захирагааны, төрийн үйлчилгээний албан хаагчдын оролцоо төлөвших хандлагатай байна.

Тухайлбал төсвийн байгууллагуд төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтын тухай хуулийн дагуу төсвийн срөнхий менежерүүдтэй үр дүнгийн гэрээ байгуулж төсөв хэмнэх, хэмнэсэн төсвийн хөрөнгийг нийгэм хамт олныхоо төлөө зарцуулах эрх нээлттэй болж байгаа учир төсвийн үйл явцад ямар нэг хэмжээгээр оролцох эдийн засгийн механизмыг сонирхол бий боллоо. Энэ талаар дэлгэрэнгүй ярилцаж болох юм.

**Төсвийн орлого бүрдүүлж байгаа ард иргэд хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу татвар, орлогын, хөрөнгийн хөдөлгөөний тайлан гаргах хэлбэрээр төсвийн үйл явцад оролцож байна.**

Мөн сүүлийн үед татвар төлөгчдийн болон даатгуулагчдын эрх ашгийг хамгаалсан төрийн бус байгууллагуд бий болж татвар орлогын бодлогод оролцох хандлагууд илэрч байна.

Цаашдаа төсвийн хөрөнгийг үр ашигтай иновчтой хувиарлах, үр ашгийг нь дээшлүүлэх чиглэлд ард иргэдийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Энэ нь татварын ачаалал дарамтыг бууруулахад зохих нөлөө үзүүлэх ач холбогдолтой байх болно.

Төсвийн үйл явцад олон түмний оролцоог нэмэгдүүлэх нэг хэлбэр нь УИХ төсөв хэлэлцэх, батлах 4 үе шатанд тодорхой зохион байгуулалттайгаар санал бодлоо илэрхийлэх, материалтай танилцах ажлыг зохион байгуулж болох юм.

Улсын төсвийн үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх төр засгийн үйл ажиллагаа ил тод байж ардчилалыг хэрэгжүүлэх, бис бисэндээ итгэх итгэлийг гүнзгийрүүлэх төдийгүй улсын төсвийн орлого төвлөрүүлэх, зарлага санхүүжилтиг арвилан хэмнэх арвич хямгач ажиллагаанд саад бэрхшээл үүсэхгүй эерэг ач холбогдолтой гэж үзэж байна.

Та бүхний санал бодлыг сонсч харилцан ярилцахад таатай байх болно.

**“УЛСЫН ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦ, 2004 ОНЫ ТӨСВИЙН ОНЦЛОГ ”  
СЭДЭВТ УУЛЗАЛТ ЯРИЛЦЛАГЫН ПРОТОКОЛ  
/ 2004-01-15 /**

**Хатагтай ноёдоо!**

МННХ-гийн Удирдах зөвлөлийн нэрийн өмнөөс “Улсын төсвийн Үйл явц, 2004 оны Төсвийн онцлог ” сэдэвт энэхүү уулзалт ярилцлагад хүрэлцэн ирсэн Та бүхний энэ оройн амгалантайтгэй.

Улсын төсөв нь Засгийн газрын нийгэм, эдийн засгийн бодлогоо хэрэгжүүлдэг хамгийн хүчирхэг зэвсэг бөгөөд энэ утгаараа ард түмний амьдралд, түүний дотор ядуу, эмзэг хэсгийнхэнд хамгийн онцгой нөлөөлдөг хүчин зүйл юм. Улсын төсвийг төлөвлөх, хэлэлцэх, батлах үйл явцад олон нийтийн оролцоог хангасан нээлттэй хэлэлцүүлгийг хэрхэн үр өгөөжтэй зохион байгуулж болох тухай хүсэл эрмэлзлээр бид энд цуглараад байна. Энэ асуудалд хамаатай бүх талууд, ялангуяа төсвийн орлогыг бүрдүүлэгчид, хандивлагчид, зарлагыг хүргтэгсэд, онцгой мэдрэгсийн оролцоотойгоор төсвийн үйл явцыг нээлттэй хэлэлцүүлж байгаа нь Монгол Улсад ардчилсан, тунгалааг засаглалыг хөгжүүлэх, ард түмэн сонгосон төрийнхөө шийдвэрийг батлахад нээлттэй оролцох сайхан уламжлалыг эхлүүлэх түүхийн нэгэн шинэ хуудсыг нээж байгаа нь өнөөдрийн энэ уулзалт ярилцлагын гол онцлог юм. Уулзалтад хүрэлцэн ирсэн Та бүхэнд баярлалаа. Уулзалтын ажиллагаанд амжилт хүсье.

**Хөтөлгөч Д.ЭНХБАТ. / Датаком ХХК-ий Еронхий захирал:/**

Ноёд, Хатагтай та бүхэнд энэ оройн мэндийг хүргэе.

өнөөдрийн уулзалт ярилцлага нь :

- СЭЗСайд Ч.Улаан “ 2004 оны төсвийн онцлог, ерөнхий чиг хандлага”
- УИХ-ын гишүүн Д.Цэвээнжав “Төсвийн үйл явц, түүн дэх иргэдийн оролцоо” сэдэвт хоёр илтгэл, панел хэлэлцүүлэг болон оролцогч та бүхний асуулт, хариулт, санал, шүүмжлэлээс бүрдэх юм. Ингээд илтгэлүүдийг сонсоцгоо.

**Санхүү Эдийн Засгийн Сайд Ч.Улаан: “2004 оны төсвийн онцлог, ерөнхий чиг хандлага”,**

**УИХ-ын гишүүн Д.Цэвээнжав: “Төсвийн үйл явц, түүн дэх иргэдийн оролцоо”**

**Хөтөлгөч Д.Энхбат :** Бид үндсэн илтгэлүүдээ сонслоо. Одоо уулзалтын дараагийн хэсэг болох панел хэлэлцүүлэгт орьё. Манай панел хэлэлцүүлэг 2 хэсгээс бүрдэнэ. 1-р хэсэг болох 2004 оны улсын төсвийн чиг хандлага болон дээрх хоёр илтгэлийн талаар ярилцах бөгөөд би панелд оролцогчдод хандан дараах асуултыг юуны өмнө тавья

**-Энэ оны төсөв нь 2002, 2003 оны төсвөөс юугаараа ялгаатай болох, ямар асуудлууд илүү анхаарал татаж байна вэ?**

**Барри Хичкок, Азийн хөгжлийн банкны Монгол дахь суурин төлөөлөгч:**

-Юуны өмнө Дэлхийн банк, ОУВС, УИХ-ын гишүүд, ноён сайд болон энд хүрэлцэн ирсэн нийт хүмүүст энэ оройн мэндийг дэвшүүлээд энэхүү ярилцлагыг зохион байгуулагчдад талархсанаа илэрхийль.

Улсын төсвийн төслийг хэлэлцэх, боловсруулах түүний гүйцэтгэл, тайланг хянах үйл явцад олон нийтийг оролцоог хангах нь чухал асуудал билээ. Аж ахуйн нэгж байгууллага, хувийн жижиг компани ч хагас жил, жилийнхээ ажлыг төлөвлөгийн нэгэн адил аливаа улсын Засгийн газар нь үйл ажиллагааныхаа ойрын болон хэтийн төлөв, төлөвлөгөөг урьчилан хэлэлцэж төсөвтөө тусгадаг. Төсвийн алдагдлыг бууруулах нь улсын санхүү, эдийн засгийг сайжруулах гол үзүүлэлт учраас энэ асуудалд анхаарлаа хандуулах ёстой. өнөөдрийн энэ уулзалт ярилцлагад оролцож байгаа гурван тал нь дээрх асуудлуудаар Засгийн газартай хамтран ажиллаж байгаа. Ингэж ажилласнаар макро эдийн засгийн шинэ түвшинд хүрч чадна гэдэгт би итгэлтэй байна.

Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй төслүүдийн хувьд манай банк 80 хувь, Монголын Засгийн газар 20 хувийн санхүүжилтийг бүрдүүлнэ. Манай байгууллагаас хэрэгжүүлж байгаа бүх төсөл нь нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн олон улсын стандартад нийцсэн байх ёстой.

**Доун Рэм, Олон Улсын Валютын Сангийн Монгол дахь суурин төлөөлөгч:**

-ОУВС төсвийн тогтвортой байдалд чухал ач холбогдол өгч ямагт анхаарч байдаг. Дунд хугацааны төсвийн санхүүжилтийг тодорхойлсон нь зөв алхам болсон. Иймээс



**Нээлттэй Нийгэм  
Форум**

★  
**“УЛСЫН ТӨСВИЙН ҮЙЛ  
ЯВЦ, 2004 ОНЫ ТЙСВИЙН  
ОНЦЛОГ ”  
СЭДЭВТ УУЛАЗАЛТ  
ЯРИЛЦЛАГЫН ПРОТОКОЛ  
/ 2004-01-15 /**

★  
**МННХ-ийн Удирдах  
зөвлөлийн гишүүн  
Д.Жаргалсайхан  
уулзалтыг нээж Үг хэлэв.**



цаашдаа ямар бодлого барих вэ гэдгээ нарийн тодорхойлох нь чухал. Энэ жилийн төсвийн өөрчлөлтийн түвшинг хараад хүн бүрт таатай сэтгэгдэл төрж байгаа байх аа. Төсөв нь өргөт, гүйцэтгэлд тулгуурласан баримт учраас түүнд бодлогын зарчмаар хандах нь илүү үр дүнтэй. Үүнд ил тод байдал ч хамаарна. Урд нь хүнд хүрдэгүй байсан мэдээллийд нээлттэй болсноор улсын төсвийн орлого, зарлага, гүйцэтгэл ямар түвшинд байгааг мэдэх боломжийг ард иргэдэд олгож буй нь нэг дэвшил юм.

#### **Хөтлөгч Д.Энхбат:**

**-ОХУ-д төлсөн өрийн асуудал сүүлийн Үед хэвлэл, мэдээллийн хэрэгслээр яригдаж байгаа гол сэдэв юм. Энэ нь 2004 оны төсөвт хэрхэн тусгагдсан тухайд Улаан сайдаас тодруульяа.**



#### **Ч.Улаан, Санхүү Эдийн Засгийн Сайд:**

-Энэ өрийг төлсөн мөнгөний эх үүсвэрийн зарим хэсэг нь 2004 оны төсөвт тусгагдсан, зарим нь тусгагдаагүй.

Засгийн газар тодорхой хэмжээний мөнгийг нөөцөөс гаргаснаас гадна жилийн гурван хувийн хүүтэй үнэт цаас борлуулсан. Ер нь Засгийн газар сүүлийн гурван жилд төсвийн алдагдлыг бууруулах, төсвийн орлогын улирлын болон цаг хугацааны хүчин зүйлийн сөрөг нөлөөллийг арилгах зорилгоор дотоодын зах зээлд үнэт цаас гаргах замаар аж ахуйн байгууллага, арилжааны банкууд, ард иргэдийн сүл чөлөөтэй хөрөнгийг тодорхой хугацаатай, нөхцөлтэйгээр зээлэн ашиглаж байгаа. Сүүлийн гурван жилд дунджаараа 50 орчим тэрбум төгрөгийн дотоод зээл гаргаж түүнийгээ хугацаанд нь тогтмол төлж барагдуулсаар ирсэн. 2003 оны 12 дугаар сарын 30-ны байдлаар авч үзвэл Монгол Улсын Засгийн газрын дотоодын зах зээлээс зээлсэн хөрөнгийн хэмжээ 75 тэрбум төгрөг байгаа. Энэ нь төсөвт нэг их хүнд ачаалал өгөхгүй. Бид 2004 оны туршид дотоод зээлээс графикийн дагуу мөнгөжүүлэх бүрэн бололцоотой. 2000 оны есдүгээр сарын 12-нд Засгийн газар анх үнэт цаас, бонд гарган борлуулж байсныг Та бүхэн санаж байгаа байх. Үүнээс хойш Засгийн газрын үнэт цаасны хүү, төлбөрийн асуудалд ямар ч хүндрэл бэрхшээл учраагүй, үүргээ байнга биелүүлсээр ирсэн. Засгийн газрын үнэт цаасанд хандах итгэл харьцангуй өндөр байсан гэдгийг хэлмээр байна. Орийн төлбөртэй холбоотойгоор хэлэхэд 2004 оны төсөвт тусгагдаагүй тодорхой хэмжээний эх үүсвэр байгаа. Үүнийг Засгийн газар УИХ-ын шийдвэрээр тодорхой хугацаанд нийхин бүрдүүлэхээр зээллэгийн хэлбэрээр авсан. Энэ нь 2004 онд тооцогдох дотоод зээллэгийн хэмжээн дээр нэмэгдсэн байх болно. Ер нь 2004 оны төсөвт зарим эх үүсвэр нь бондын хэлбэрээр тусгагдсан байгаа.

Мөн 2003 оны төсвийн гүйцэтгэлээс төлбөрийн зарим хэсгийг барагдуулсан. Эдгээр гурван эх үүсвэрээс ОХУ-д төлсөн мөнгөний дүнг бүрдүүлсэн юм.

#### **Хөтлөгч Д.Энхбат :**

-Одоо хэлэлцүүлгийнхээ хоёрдугаар хэсэгт орьё. Энд бид улсын төсвийг боловсруулах, хэлэлцэх, батлах, хэрэгжүүлэх бүхий л үс шатанд иргэдийн оролцоо ямар байх тухай ярилцана.

**-Улсын төсвийн асуудалтай холбон ойлгоход ил тод байдал (тунгалаг байдал ч гэж нэрлэж байгаа) гэж чухам юуг хэлж байгаа юм бэ? Мөн ил тод байдлын талаар олон улсын хүрээнд нэгдсэн стандарт ойлголт байдаг уу, эсвэл орон бүр өөрсдийнхөөрөө ойлгож байна уу? Энэ талаар оролцож байгаа олон улсын байгууллагын гишүүд болон манай хоёр илтгэгчээс асуух гэсэн юм.**

#### **Саха Мөянатан, Дэлхийн банкны Монгол дахь суурин төлөөлөгч:**

ОХУ-д төлөх өртэй холбоотойгоор хэлэхэд нэгэнт өр л учраас түүнийг төлж барагдуулах нь зайлшгүй. Үүнээс шалтгаалан Монголд хандивлагчдын хурлаар аливаа асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд байнга болгоомжлол байсныг үгүйсгэхгүй.

Ил тод байдлын талаар асуулаа. Энэ бол миний төрсөн нутаг болох Малайзад жилийн дөрвөн улирлын турш байнга яригдаж байдаг асуудлын нэг юм. Манай нутагт аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллагууд, жишээлэхэд, загасчдын нийгэмлэг гэхэд л улсын төсөвт тусгахыг хүссэн асуудлаа дотроо хэлэлцэн шийдвэрлээд Засгийн газарт саналаа тавьдаг. Ингэснээр тухайн салбар нэгжийн тулгамдсан асуудал, шаардлагатай зүйлсийг судалж хянан улмаар төсвийн төсөлд тусгах боломж Засгийн газарт нээгддэг. Үүний дунд төсвийн төслийн явц дахь иргэдийн оролцоог хангахаас гадна Засгийн газар үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй байлгаж чаддаг юм.



## Доун Рэм, Олон Улсын Валютын Сангийн суурин төлөөлогч:

Би Орост төлсөн өрийн талаар болгоомжтой хэдэн үг хэлмээр байна. Яагаад гэвэл, ОУВС-гийн зүгээс бараг арван янзын байр суурьтай байна гэсэн мэдээлэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр бичигдэж байсан. Энэ бол маш урт хугацаанд байсан өр юм. Энэ өрийн үр нөлөө улсын төсөвт хэрхэн нөлөөлөх, ямар байдлаар тусгагдахыг мэдэхгүй байсан учраас хөрөнгө оруулалтад тодорхой хэмжээгээр нөлөөлөх хандлага байсан. Энэ жилийн төсвийн төсөлд ямар үр нөлөө үзүүлэх вэ гэдэг талаар бид дүн шинжилгээ хийж, тодорхой үзүүлэлтүүдийг шалгаж үзэх шаардлагатай. Бидний цаасан дээр буулгасан бүх тоо нь ямар нэг болзошгүй эрсдэлийг тусгаагүй байгаа.

Ил тод байдлын тухайд бол Монгол Улс, ОУВС-гийн хооронд төсвийн ил тод байдлыг хангах стандарт гэж байдаг. Төсвийн бүрдүүлэлт, хэрэгжилтийг нээлттэй болгох, цаашид тайланд тусгагда бүх тоог үнэн зөв бичиж, нэгдмэл байдлыг хангах талаар тодорхой шаардлагыг тавьж ажилладаг. Төсвийг ил тод, тодорхой бодлогын хүрээнд төлөвлөж энэ жил, дараа жил, түүний дараа жилийн бодлого ямар байх вэ гэдгийг тодорхойлсны үндсэн дээр тогтоодог. Бодлогын арга хэмжээг төсөвт ямар байдлаар тусгахыг улам бүр ил тод, тодорхой болгох талаар нэлээд зүйлийг хийж байгаа. Санхүүгийн нэгдмэл менежментийн тогтолцоо, тайлagnal гэх мэт үйл явцыг нэлээд нэгдмэл хэлбэртэй болгож ирсэн. Ил тод байдалд тавигдах шаардлагын талаар хэрэгжүүлэх дараагийн нэг алхам бол мэдээллийг олон нийтэд хэрхэн, ямар хэлбэрээр хүргэх вэ гэдгийг тодорхойлох явдал. Энэ бол хүмүүс мэдээллийг өөр хоорондоо хэлэлцэж, ЗГ-ын бодлого, хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар ярилцаж, санаа бодлоо илэрхийлэх боломжийн тухай асуудал юм. Түүнчлэн хүний нөөцийн удирдлагын системийг хэрэгжүүлснээр төрийн албаны шинэчлэлийн хөтөлбөрийн хэрэгжилт, төсвийн нийт зарцуулалтыг нэмэгдүүлэхгүйгээр багасгах арга хэмжээний гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх бололцоо бүрдэнэ.



## Ч.Улаан, Санхүү Эдийн Засгийн Сайд:

Төсвийн ил тод байдлыг хангах талаар хатуу тогтоосон стандарт, жишиг одоогоор алга. Гэхдээ олон улсын байгууллага, ЗГ-ын хамтын ажиллагаанд тогтсон зарчим бол бий. Ер нь ил тод байхын тулд ямар мэдээллийг ил тод мэдээлэх талаар бид байнга зөвлөлдөж ажилладаг. Засгийн газарт ямарваа нэг мэдээллийг нуух, эсвэл ил болгохгүй гэх сонирхол байхгүй. ОУВС, Дэлхийн банктай хамтарч өмнөх жилүүдийн төсвийн гүйцэтгэл, тайлан, бодлого боловсруулалтын талаарх бүх мэдээллийг ил тодоор нийтлэхийг бид санал нэгтгээгээр зөвшөөрч байгаа. Монгол Улсын эдийн засгийн шалгуур үзүүлэлтүүдийг Дэлхийн банкнаас үнэлсэн тухай ярилцаад үүнийг захирлуудын зөвлөлөөр хэлэлцэн дараа нь нээлттэй вэб сайтад тавьж нийтэд сурталчилыг гэж өнгигдрийг хүргэл бил ярьсан. Нөгөө талаар төсвийг ил тод байлгахад хоёр гол зангилаа асуудал бий. Юуны өмнө бодлого боловсруулах явцад аль болох ил тод байж олон нийтийг өргөн оролцуулах, иргэний нийгмийн оролцоог хангах чиглэлээр бил нэлээд тодорхой алхмуудыг хийсэн. Ялангуяа, ядуурлыг бууруулах дунд хугацааны бодлогыг гаргаж ирэхэд нэлээд өргөн хүрээнд зөвлөлдөж, олон удаа хамтарч ярилцсан. Энэ бол нээлттэй байгаагийн нэг тод илрэл гэж бодож байна.

2003 оноос “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль” хэрэгжсэнээр төсөв боловсруулах явц өөрөө нээлттэй болсон. Хуучин бол дээд байгууллагаас татвар тогтоогоод түүнд нь багтааж төсвөө гаргадаг байсан бол одоо тодорхой хэмжээний шалгуур үзүүлэлтийг тогтоосны үндсэн дээр доод түвшнээсээ эхлэн төсвөө боловсруулдаг. Энэ маягаар төсвийн бодлого боловсруулах явцыг нээлттэй болгож, олон нийтийн оролцоог хангах боломжийг бүрдүүлж байна. Тэрчлэн төсвийн хуулийн хэрэгжилт, тайлagnalын ил тод байдлыг урамшуулах тогтолцоонд шилжсэнээр төсвийн бүх эрх захирагчдын үйл ажиллагаа ил тод болж байгаа юм. Омнө нь төсвийн эрх захирагчид нь тодорхой хэмжээний орлогыг өөрөө олдог. Тэр нь голдуу хаалттай байдаг. Харин төвөөс авдаг санхүүгийн эх үүсвэр нь нээлттэй. Бүгдээрээ тэр рүүгээ хошуурдаг байсан бол одоо өөрийнх нь олж байгаа орлого, зарцуулж байгаа зарлага нь ил болсон. Энэ онд улсын төсвийг батлахдаа төсвийн эрх захирагч нэг бүрээр баталсан. Гэхдээ орлого, зарлагыг бүр тодорхой зааж өгсөн. Тэгэхээр 2004 оны төсвийн хэрэгжилтийн явцад иргэний нийгэм тодорхой хяналт тавих бололцоо бүрдсэн байгаа. Орлогоо яаж бүрдүүлж, хэрхэн зарцуулж байгаа нь ил тодоор хуульчлагдаж нийтэд зарлагдсан учраас энэ байдал дээшлэх боломж бүрдсэн.



## Д.Цэвээнжав, УИХ-ын гишүүн:

Төсвийн ил тод байдлын тухай ярихад бас нэг зүйлийг анхаарч зэх ёстой юм. Монгол Улсын төсөв нь өөрөө хууль болон батлагддаг. Хууль болж батлагддаг учраас төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, түүний тайлан, удирдлагын арга барил ил тод гарч чадаг төдийгүй түүний доторх үзүүлэлтүүд маш ойлгомжтой, тодорхой байх учиртай. Төсвийг ил тод ойлгомжтой байлгах үүднээс олон улсын стандартын түвшинд авч үзэхэд төсвийн орлого,



түүний дотор татварын орлого, төсвийн зарлага, алдагдлын хэмжээг ДНБ-тэй харьцуулж жил бүр гаргадаг. Төсөв боловсруулах, батлах явцад энэ үндсэн үзүүлэлтүүдийн харьцааг анхааран үздэгээс төсөв анхнаасаа ил тод байдаг гэж хэлж болох юм. Ер нь төсвийг зөвхөн тухайн жилийнхээс гадна дунд хугацаагаар авч үздэг нь төсвийн цаашдын хандлагыг олон түмэн ил тод ойлгож харах боломжийг бий болгож байна.

### **Барри Хичкок, Азиин хөгжлийн банк:**

Ил тод байдал нь түүгээр юуг илэрхийлэх гэж байгаагаас ихээхэн хамааралтай. Төсвийн нөхцөлийг сайжруулахад эерэг нөлөө үзүүлдэг төрийн олон байгууллага байдаг. Нэгдгүйгээрт, мэдээж парламент. Аль ч парламент төсөв зохиохдоо олон нийтийн сонирхолд өртдөг хууль тогтоомжуудыг авч үздэг. Гэхдээ төсөв зохиож байгаа парламентын үйл ажиллагааны техникийн чадавхийг сайжруулах боломжийг хангах хэрэгтэй. Хоёрдугаарт, телевиз радио зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь төсөвтэй холбоотой аливаа асуудал, бодлогуудыг олон нийтэд танилцуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь техникийн чадавхийн хувьд сайн, түүнчлэн төсвийн талаарх аливаа нийтлэлийг бичиж бэлтгэх туршлагатай байх хэрэгтэй. Гуравдугаарт, миний бодож байгаагаар төсвийн асуудалд эрдэм шинжилгээний байгууллагууд ихээхэн үүрэг рольтой. Монголд ийм байгууллага олон бий. Дээрх бүх байгууллага төсвийн талаар олон нийтэд чанартай мэдээлэл хүргэх үүрэг гүйцэтгэдэг.

### **Хотлогч Д.Энхбат:**

**-Манай УИХ, Засгийн газар ил тод байдлыг мэдээж хэрэг зарчмын хувьд ойлгож дэмжиж байгаа. Тэгэхээр нэг ийм асуулт байна. Ил тод байдлыг чухам яг яаж хэмжих вэ? Жишээ нь, 2004 онд 2003 оноос илүү ил тод болсон гэдгийг яаж мэдэх вэ? Засгийн газар тодорхой зүйл төлөвлөөд ийм байдлаар илүү ил тод болсон гэвэл юуг хэлэх вэ?**

### **Ч.Улаан, Санхүү Эдийн Засгийн Сайд:**

Засгийн газар яаж ил тод болж байна гэдгийг яг таг хэмжих шалгуур өнөөдөр алга, өмнөхтэйгээ харьцуулахад ямар өөрчлөлт орсон бэ гэвэл тодорхой алхам, жишээнүүдийг дурдаж болно. Жишээлбэл, бил “Нээлттэй засаг” гэдэг вэб сайт нээж түүгээрээ дамжуулан сонирхож байгаа хүмүүсийн саналыг авч, тэдэнтэй эргэж харьсан, бодлого боловсруулаадаа харгалзан үздэг жишигийг өнөөдөр хэвшүүлж байна. Долоо хоног бүр тодорхой яам, Засгийн газрын гишүүн энэ вэб сайтыг хариуцаж, долоо хоногийнхоо дүнг нэгтгэн, анхаарал татаж байгаа асуудлыг танхимд танилцуулдаг. Мөн энэ сайгад шинэ бодлогын асуудлууд, хуулийн төслийг тавьж нийтэд хэлэлцүүлдэг журамтай. Энэ бол ил тод байдлын нэг хэлбэр. Ард иргэдтэй аль болох нээлтгэй, чөлөөтэй уулзаж ярилцах, тэдний санаа бодлыг сонсож бодлого боловсруулаадаа тусгах чиглэлээр тодорхой алхам, ахишуудыг гаргаж байгаа. Энэ бол өмнөх оноос ялгарах нэг өөрчлөлт юм. Ил тод байдлыг хангахтай холбоотой дараагийн нэг асуудал бол Засгийн газрын мэдээллийг иргэдэд чөлөөтэй хүргэх явдал. Харин яг ил тод байдал төдөн хувь гээд хэлэх тийм шалгуур хаана байна, байвал тооцъё, тогтоож Узье.Үүнээс хойшоо суух ямар нэг явдал алга.



### **Доун Рэм, Олон Улсын Валютын Сан:**

Энэ бол стандарт шаардлагуудыг хянан үзэхтэй холбоотой асуудал. Үүнийг хууль санаачлагч хийж болохгүй. Харин Засгийн газрын зүгээс хүсэлт гаргасны үндсэн дээр явуулах ёстой. Бид энэ шаардлагыг өөрийн хэмжээнд шинэчлэх ажлыг дэлхий нийтийн хамгийн сайн дадлага туршилага дээр тулгуурлан хийж байгаа.

### **Хотлогч Д.Энхбат:**

Миний ойлгосноор ил тод байдлын индекс гэж мэдээж хэрэг байдаг байх. Би өөрөө мэдэхгүй юм байна. Тэгэхээр Засгийн газар энэ чиглэлийн байгууллагатай ирэх онд хамтарч ажиллах сайхан ирээдүй бий гэсэн өөдрөг санаан дээр панел хэлэлцүүлгийг дуусгая. Одоо асуулт хариултын хэсэгт шилжихээсээ өмнө удирдлагаас өгсөн үүргийн дагуу би дурмээ товч танилцуулья. Дүрэм маань маш энгийн. Асуултыг товч, давтагдуулалгүйгээр асууна. Санал бодлоо хоёр минутад багтаан ярина уу. Мөн Нээлттэй Нийгэм Форумын явцад тавьж байгаа нэг дүрэм нь тодорхой хүн, байгууллагын нэр дээр шүүмжлэл өрнүүлэхгүй. Бид асуудлыг хамтран шийдэж байгаа учраас зарчмын зүйлүүдээ өхлээд ярья. Асуултыг гурав дөрвөн хүн тавьсны дараа панелд оролцогчид хариултыг өгнө. Санал мийн адил. Дүрэм ёсоор эхлээд өөрийгөө танилцуулах ёстой.



## Р.Бурмаа, Сонгогчдын боловсрол төвийн захирал:

Улаан сайдаас асууяа:

-Мэдээллийн дутмаг байдал, бүрэн нээлттэй орчин нэг талаар хээл хахууль бий болох орчныг бүрдүүлдэг, ногөө талаар ард иргэдийн дунд бүрхэг таамаглал, буруу ташаа ойлголтыг төрүүлдэг гэж Тя ярьсан. Мэдээллийн бүрэн нээлттэй орчин яагаад хээл хахуулийг бий болгож ард иргэдийн дунд буруу ташаа ойлголтыг төрүүлдэг юм бэ?

-Жил бүрийн төсвийн төслийг боловсруулах явцад олон нийтийн байгууллагуудыг оролцуулдаг гэж байна. Яаж оролцдог юм бэ?

Цэвээнжав гишүүнээс асуухад::

-Орон нутгийн төсвийг аймаг нийслэлийн ИТХ-аар хэлэлцэж баталдаг гэсэн. Яаж хэлэлцэх вэ? Арай дэлгэрэнгүй хэлэхгүй юу? Жишээ нь, төсвийг боловсруулахаас эхлээд хуульчлан батлах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах үйл явцад аймаг нийслэлийн ИТХ яаж оролцдог юм бэ?

## Н.Дашэвэг, Монголын үндэсний аж үйлдвэрлэгчдийн холбооны тэргүүн:

-Өнгөрсон онд ОУВС буурай хөгжилтэй орнуудын орчныг тэглэсэн. J-8-д Орос орсон учраас Монголын орчны асуудлыг тэглэх буюу ОУВС-ийн шинэ заавраар, оорөөр хэлбэл, дамжуурлын процесс зарлана гэсэн хувилбараар манай орчны шийдэх боломж байгаагүй юу?

-Монголын 21 аймаг ажилгүй, ядуу хүмүүсээр дүүрчээ. Тэгвэл орон нутагт байгаа үйлдвэрүүдийг татвараар нь хөнгөөд тэр хүмүүсийг ажилтай болгох болох уу? УИХ орон нутагт байгуулагдаж байгаа үйлдвэрүүдийг татвараас чөлөөлөх хууль гаргасан боловч ОУВС зовшөөрөхгүй байна гээд оноодор төрийн хууль үйлчлэхгүй байна.

## Хөтлөгч Д.ЭНХБАТ:

Энд бид төсвийн болон ил тод байдлын талаар голчлон ярилцана. Дээрх асуулт мэдээж их чухал асуудал. Гэхдээ өнөөдөр энд сууж байгаа хүмүүсийн өмнө энэ асуудлыг ярих уу, үгүй юу гэдгийг бодож үзэх хэрэгтэй. Дараагийн хүмүүс ч үүн дээр анхаарна биз. Тиймээс яг өнөөдрийн сэдэв болох төсвийн болон түүний ил тод байдлын талаар л ярилцья.

## Н.ХАШЧУЛУУН, Эдийн засгийн бодлогын судалгааны ассоциаци:

Улаан сайдаас асуухад:

-2004 оны төсөв уг нь их онцлогтой юм. Үүний талаар арай дутуу ярилаа гэж бодож байна. Өмнөх жилээс цикл нь оөр, дунд хугацааны стратегийг боловсруулсан. 2004 оноос шинэ маягаар төсвийн зохион байгуулалт хийнэ. Энд ямар оөрчлөлт орох вэ?

-Төсвийн байгууллага, нэгж дээр ил тод байдал тэр бүр хангалттай байж чаддаггүй. Жишээлбэл, төрийн байгууллагуудын төсвийн зарцуулалт ил тод байдаг уу гэвэл үгүй байх гэж санагдаж байна.

**Хотлөгч Д.Энхбат :** Эхний удаад асуултаа үүгээр таслаяа.

## Ч.УЛААН, Санхүү Эдийн Засгийн Сайд

-Хэрэв мэдээлэл ил тод бус байвал яж нөлөөлдөг вэ гэсэн асуултад хариульяа. Хэрэв төслийн хуулийг хэрэгжүүлэх, хөрөнгө мөнгийг зарцуулах явцад хяналтгүй, түүний үр дүнгийн талаар мэдээлэл байхгүй бол хууль зөрчих, буруу үйл ажиллагаа явуулах, төсвийн хөрөнгийг үрэн таран хийх явдал гардаг. Урд нь ч гарч байсан. Төсвийн хяналт муу байснаас болоод 30 жил хэрэглэх эрээн даавууг нэг яамны төсөвт шахчихсан байх жишээтэй. Тэгхээр энэ нь цаанаа ямар нэг байдлаар хээл хахуультай холбогдож л байгаа. Яахаараа 30 жилийн хэрэгцээг нэг жилд худалдаж авдаг юм. Ер нь ил тод биш, хяналтгүй байх нь хууль зөрчих, цаашилбал олон сөрөг үр дагавар гарахад хүргэдэг учраас үүнийг би цохон тэмдэглэсэн юм. Тиймээс бүрдүүлж байгаа төсөв ч, зарцуулж байгаа төсөв ч, энэ талаарх мэдээлэл ч ил тод нийтэд хүртээмжтэй байх ёстой.

Дашзэвэгийн асуулт надад бараг хамаагүй юм байна. Тиймээс Хашчулууны асуултад хариульяа.

Дунд хугацааны стратеги дээр үндэслэгдэж боловсрогдсон нь 2004 оны төсвийн нэг онцлог юм. Гэхдээ “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль” 2003 оны нэгдүгээр сарын нэгнээс хэрэгжсэн учраас үүн дээр акцент өгөөгүй. Дунд хугацаанд буюу Монгол Улсын 2007 он хүртэлх эдийн засгийн үндсэн бодлого, санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах стратеги, энэ хугацаанд явуулах төрийн албаны оөрчлөлт

шинэчлэлтийн бодлогыг Засгийн газар олон улсын байгууллагатай хамтраад гаргасан бас нэг гол онцлог юм. Мөн ОУВС-тай хамтран ядуурлыг бууруулах төслийг хангах хөтөлбөр, Дэлхийн банк, Валютийн сангийн захирлуудын зөвлөлийн хамтарсан хуралдаанаар хэлэлцээд Монголд ядуурлыг арилгах стратегийн баримт бичгийг гаргасан. Эдгээр нь дунд хугацааны бодлогууд. Урт хугцаанд тогтвортой, үр ашигтай бодлого явуулах журманд шилжсэн нь энэ оны төсөв батласан өөр нэг онцлог гэж би бодож байна. Гурван жилээр гаргасан төсвийн бодлогын хүрээнд багтаагаад төсвийн эрх захирагчид өөрсдөө бодлогоо тодорхойлох, тэнцэлдээ хяналт тавих, тайлagnaх бололцоог нь нээлттэй болгох зарчмыг баримталж байгаа. Төсвийн зарцуулалтын ил тод байдлыг хангахад бид цаащаа нэлээд тодорхой үе шат бүхий алхмуудыг хийнэ. Улсын төсвийн гүйцэтгэлийн тайланг УИХ хэлэлцэж баталдаг хуультай. Урьд нь зарим жил баталж, зарим жил нь батлахгүй ч байсан явдал бий. Сүүлийн гурван жил УИХ гүйцэтгэлийн тайланг баталж байгаа. 2003 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг батлахаа УИХ нэлээд өргөн хүрээнд авч үзсэн. Дараагийн нэг алхам бол төсвийн гүйцэтгэлийн байдлыг төсвийн эрх захирагчид нийтэд ил тод болгох асуудал. Энэ бол нийтлэг шаардлага гэдгийг бид яамдуудад тавьж байгаа. Төсвийн гүйцэтгэл, хэрэгжилтийн байдлаа эрх захирагч нар өөр өөрсдийн эрхэлсэн ажлын хүрээнд ил тод болгоно гэдгийг бодлого болгон явуулж байгаа учраас цаащаа улам өргөжих юм.

#### **Д.Цэвээнжав, УИХ-ын гишүүн:**

Орон нутгийн төсвийг аймаг нийслэлийн ИТХ баталдаг. Цикл нь яг адил байх уу гэсэн утгатай асуулт асуулаа. Ер нь зарчим бол адилхан. Гэхдээ өнөөдрийн УИХ улсын төсвийг дөрвөн үе шатаар хэлэлцэж байгаа шиг орон нутгийн иргэдийн хурал хэлэлцэж чадахгүй байгаа. Боловсруулалтын шат нь харьцангуй богино. Мөн төсвөө хэлэлцэхээсээ өмнө энэ чиглэлийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны тийв байгууллагатай төсвөө уялдуулах хандлага бий. Энэ нь миний илтгэлд яригдсан төсвийн өрөнхий захирагчтай гэрээ байгуулдаг зарчмаар нэмж баяжиж байгаа гэдгийг хэлмээр байна.

Хашчуууны асуулттай холбогдуулж хэлэхэд, улсын хэмжээнд таван сая төгрөгөөс дээш хөрөнгө оруулалт, их засвар, ажил үйлчилгээг бүтээх үнийг худалдан авахад тендерийн хууль хэрэгжих байгаа. Энэ дагуу олон түмэнд нээлттэй ил тодоор тендер зарлаж байгаа нь төсвийн гүйцэтгэлийн ил тод байдал юм. Үүнийг цаащаа аль болох бүрэн гүйцэд хэрэгжүүлэх талаар анхаарал тавьж байна. Эхний жилүүдэд дутагдалтай асуудлууд байгааг үгүйсгэхгүй.

#### **Доун Рэм, Олон Улсын Валютын Сан:**

-Би хариултаа аль болох товчлоё. Ямар нэгэн улс оронд өрийг тэглэх хэмжээнд яригдах асуудал, үзүүлэлтүүд байдаг. Монгол Улс J-8 –н хүрээнд өрийг тэглэдэг тэр хэсэгт хамрагдах түвшинд хүрээгүй байгаа.

Манай хоёр орны байгууллагын хамтын ажиллагаа, харилцан яриа хэлэлцээрт оролцож үзээгүй болохоор та бүхэн мэдэхгүй байх. Бид нэг нэгэндээ туйлын ил тод, нээлттэй, бис бисээсээ давуу байр суурь байхгүй.

Монголд хувийн хэвшлийг бий болгох эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх нь чухал гэж ажилгүйдлийн тухайд хэлмээр байна.

#### **Санал : Ж.Занаа, CEDAW WATCH:**

-Бурмаагийн асуулт их чухал асуудал. Яагаад гэвэл ил тод байдал, иргэдийн оролцооны талаар ярихдаа Засгийн газар ямар шалгуурыг баримтлах ёстой вэ гэвэл иргэдийн төлөөлөл буюу иргэдийг албан ёсоор төлөөлж байгаа аймаг нийслэлийн иргэдийн хурлын төсөвт оролцооны асуудлын эрх хэмжээг дээшлүүлж өгөх ёстой. Хоёр илтгэгч хоёулаа ил тод байдал, иргэдийн оролцооны асуудлын өрөнхий үзэл баримтлалыг сайн гаргаж шийдээгүй учраас ил тод байдал, оролцоо гээд хэлээд байгаа жишээнүүд нь өрөнхийдөө хийсвэр боллоо гэж би бодож байна. Иргэдийн оролцоо гэхээр Цэвээнжав гуайн илтгэлд “сонинд мэдээлдэг, интернэтэд тавьдаг, 120 мянган төрийн ажилтан албан хаагчид төсвөөс хүртдэг, 900 гаруй мянган хүн төсвийг бүрдүүлэхэд оролцдог” гэсэн иймэрхүү байдлаар дүгнэлээ. Оролцоо гэдэг нь заавал хоёр талын үйл ажиллагаа байх ёстой. Энэ нь нэг талаас төр, нөгөө талаас иргэд. Иргэд нь оролцоо гээд байгаа юм аа сайн мэдэх ёстой. Тиймээс иргэдийн мэдлэг нь оролцооны нэг шалгуур болох юм. Оөрөөр хэлбэл, иргэд мэдлэгтүйгээр яж үр ашигтай оролцоо вэ гэдэг асуудалд Засгийн газар анхаарах ёстой. Төсвийг яаж унших талаар бид өнөөдөр иргэддээ боловсрол олгох нь зүйтэй. Төсвийг, жишээ нь, аль нэг сонин дээр хараа муутай хүн уншиж чадахгүй жижигхэн хэмжээгээр гаргах юм бол энэ чинь ил тод нээлттэй байдлыг бий болгож байгаа хэлбэр бас биш л дээ. Иргэдийн оролцоог бий болгохын тулд мэдээллийн төвүүд байдаг юм уу, тэнд нь иргэд очоод өнөөдөр будаа, гурил, махны ханш яаж унав, яаж нэмэгдэж байна гэдгийг хараад сууж байдаг том самбартай ч юм уу, эсвэл ямар нэг байдлаар хянадаг, шалгадаг механизмийг нь бүрдүүлж өгөх хэрэгтэй.

Тэгэхгүй бол иргэд оролцохгүй. Зүгээр сонсоод яваад байна гэдэг бол оролцож байгаа асуудал биш ээ. Тиймээс заавал хоёр талын байдлыг нь харж үзэж байж тэр шалгуур, үзүүлэлтийг бүрдүүлнэ. Энэ дашрамд хэлэхэд, иргэний нийгмийн байгууллагууд нийлээд Ардчиллыг дэмжих бүлэг гэж байгуулсан. Бид иргэний нийгмийн үзүүлэлтийн индексийг 73 шалгуураар гаргахаар төлөвлөж байгаа. Үүнд ил тод байдал, оролцоо гэж чухам юу вэ гэдэг талаар асуултууд бий. Ер нь хэлбэрдэх биш, чанарын асуудлыг анхаарах шаардлагатай.

#### А. Цэнгүүн, Алтан Тариа компани:

Улаан сайдаас асуух асуулт байна.

-Төсвийн талаар гурван баримт байна. Энэ тоонууд нь таараахгүй юм. Надад жинхэнэ бодит тоо хэлж өгөөч. Төсвийн орлого, зарлага нь хэдэн миллиард юм бэ? ДНБ-ийг яг хэдэн миллиард гэж тооцоод байгаа юм бэ? Энэ материалуудаар бол гурван өөр вариант гарч ирээд байна л даа. 79, 82, 112 тэрбум төгрөгийн алдагдал байна. Эндээс харахад ДНБ 200, 300 тэрбум юм уу, харьцуулахаар бараг 8 хувь гарч байгаа. Ногоо талаас төсвийн зардал нь 34 хувь, 35 хувь гэж аль тоогоор нь хасаад байна вэ. Энэ талаарх мэдээлэл өрөөсөө хангалтгүй байна. Яг аль мэдээлэл нь үнэн төсвийн хууль юм бэ гэдгийт хэлж өгөхгүй юу?

-Ер нь төсвийн алдагдал нь ДНБ-ний хувьд нь харьцуулахад 10 гараад явчихдаг, эсвэл зардал нь 50 хувь хүрчихдэг юм бол ямар хариуцлага тооцох вэ? Хариуцлага тооцлогтүй бол ингэж ярих ямар утга байгаа юм бэ?

#### Ж. Үнэнбат, Монголын банкуудын холбооны гүйцэтгэх захирал:

Улаан сайдаас техникийн шинж чанартай асуулт асууя.

-250 сая доллар төлсөн гэж байгаа тийм үү? Та өөрийн эх үүсвэрээс хэд, үнэт цаас гаргаж хэд, зээллэг авч хэдийг нь бүрдүүлсэн гэдгийг задалж хэлж өгөхгүй юу?

#### н. Болд, ИЗ-БНН-ын эдийн застийн бодлогын зөвлөх:

**Улаан сайдаас өрийн талаар асуух асуулт байна.**

-Оросын Засгийн газраас ирүүлсэн бичгээр бол Монголын Засгийн газар үүргээ биелүүлсэн юм шиг байгаа юм. 250 сая төгрөгийг төлсөн ч гээд тийлийгүй ч гээд байгаа. Дотооддоо өртэй болоод үлдсэн. Энэ өрийг олон янзаар тайлбарлаад байна. Тухайлбал, 10-аад хоногийн өмнө Монгол банкны ерөнхийлөгч Чулуунбаатар улсын валютын албан нөөцөөс 87 сая доллар төлсөн гэж ярьсан. Гэтэл өчигдөр “Зууны мэдээ” сонинд нөөцөөс мөнгө төлөөгүй гэсэн байсан. Та өнөөдөр нөөцөөс зарим хэсгийг төлсөн гээд ярьчихлаа. Засгийн газар энэ 250 сая долларын асуудлыг ил тод хэлчихэж бодлоггүй юм уу?

2004 оны төсөвт 50-60 тэрбум төгрөгийн бонд гаргаж энэ их өрийг төлөхөд зарцуулна гэж байна. Бондын хүүг та сарын 3 хувь гэлээ. Энэ үнэн үү, эсвэл та андуураад хэлчихэв үү?

#### Хотлогч Д.Энхбат :

Цаг болсон. Одоо асуултаяа хаая. Би нэг зүйлийг Та бүхнээс хүсмээр байна. Бид өнөөдөр өрийн санхүүгийн асуудлыг нарийн ярих гэж цуглаагүй. Би өрийн тухайд төсвийн бүтцэд хэрхэн нөлөөлж байгаа талаар л асуусан. Улаан сайдаас хүсэхэд та хариулж болно. Нөгөө талаар цаг хэмнэх үүднээс хаана хэвлэж, хэзээ хэдний өдөр тавихаа амлаж болно. Одоо хариултдаа орьё.

#### Ч.Улаан, Санхүү Эдийн Засгийн Сайд:

Цэнгүүний асуусан тоо, аль нь үнэн юм бэ гэдгээс эхлээ. Батлагдсан хууль сонинд хэвлэгдсэн. Та бүгдийг төөрөгдүүлж байгаа асуудал бол улсын, орон нутгийн, улсын нэгдсэн төсөв гэсэн гурван үзүүлэлтийн хооронд ойлголт сарниад байж магадгүй. Улсын нэгдсэн төсвөөр нь хууль гарч батлагдан сонинд хэвлэгдсэн учраас үүгээр явах нь зүйтэй юм. Энэ хуулийн дагуу улсын төсвийн алдагдал 5,9 хувь байгаа. Энэ нь зөв үзүүлэлт.

Алдагдал 10 гараад явчих юм. Хариуцлага тооцохгүй бол ямар хэрэг байна гэлээ. Алдагдал төд болвол хариуцлага хүлээнэ гэсэн эрх зүйн акт манайд байхгүй. Үрд нь 12,8 хувь хүрчихсэн алдагдалтай явж байсан. Тэр үед эдийн засаг маань өөрөө хямралтай, өрөнд баригдсан ийм л хэцүү үе байсан. Төсвийн алдагдал 15 хувь болж байсан үе бий. 1991 онд. Энэ үед эдийн засаг мөн л гүн хямралд орсон байсан. Тиймээс эдийн засгaa эрүүлжүүлж байгаа нэг гол шинж тэмдэг бол төсвийн алдагдлын үзүүлэлт юм. Цаашдаа Засгийн газрын аливаа үйл ажиллагаа төсөв нь хэр эрүүлжиж байна, төсвийн алдагдал нь хэр буурч байна гэдгээр нь үнэлж дүгнэгдэх ёстой байх аа. Хариуцлагыг ард түмэн нэгтгэж байгаад сонгуулиар тооцшихдог. Эдийн засаг, үйлдвэрлэл хямралтай байсан бол сонголтоо хийдэг учраас бас хариуцлага байгаа байх гэж би бодож байна.

Ор төлсөн эх үүсвэрийг задалж өгөөч. Үүнийг яагаад ил тод зарлачихдагтүй юм бэ гэсэн асуултууд гарч байна. Би товч хариулья. Энэ нь өнөөдрийн ярианы шууд сэдэв биш юм. Ямар ч байсан гадна талд байсан дарамттай их хэмжээний өрийг ихээхэн багасгаад дотроо оруулаад ирлээ. Тэгээд өөрийнхөө дотоод эх үүсвэрээр шийдчихлээ. Энэ шийдсэн шүү. Тийм ч учраас өр хаагдаад Оросын тал Монгол Улс манай өмнө ямар нэг үүрэг хариуцлагай гэж байгаа юм. Гэхдээ дотроо бол 2004 оныг дуустал тодорхой хэмжээний ачаалал билдэнд ирсэн. Энэ нь Засгийн газрын үнэт цаас хэлбэрээр борлогдсон 50 сая долларыг би хэлж байна. Үүнийг энэ онд төлж дуусгах ёстой. Энэ 50 саяын бондын жилийн хүү нь турван хувь юм. Төгрөгөөр гаргасан Үнэт цаасны жилийн хүү нь 14 хувь байгаа. Тиймээс бондыг доллараар гаргах нь хүүгийн хувьд ч, үлдэх зардлын хувьд ч билдэнд хөнгөлөлттэй. Нөгөө талаар борлогдох боломжийг нь харгалзан үзсэн. Ямар чбайсан энэ оны улсын төсвийн хэрэгжилтийг зохион байгуулахад дотоодын энэ зээл нь хүнд дарамт болохгүй гэдгийг би удаа дараа баталж байгаа. Амьдрал, үнэн хоёрын хооронд дийрвхийн хуруу зайд бий. Хагас жилээр нэг дүгнэе, жилийн эцсээр нэг дүгнээд харья. Төсвийн орлого нь төлөвлөснөөрөө бүрдээд, зардал санхүүжилт нь тэр хэмжээгээрээ хийгдээд оны эцэст Засгийн газрын дотоод өр багасч гарвал миний хэлсэн үнэн гэдэг нь нотлогдоно. Ямар ч байсан энэ оны эхний сард батлагдсан төсвийн дагуу зардал санхүүжилт нь саадгүй хийгдээд явж байгаа.



#### **Хөтлогч Д.Энхбат :**

- Ерөнхийдөө манай цаг дуусчихлаа. Гэхдээ хүмүүс гар өргүйд байгаа учраас хоёрхон асуулт авья. Та бүгдээс хүсэхэд бид гол нь иргэдийн оролцооны талаар анхаарч байгаа.



#### **Б.Сайнзаяа, Эрх зүйн шинэгэлийг дэмжих төвийн тэргүүн:**

**Улаан сайдаас нэг л асуулт асууя.**

-Иргэний хувьд, би Хоёрдугаар эмнэлэг, Чингэлтэй дүүргийн цагдаагийн газар, СЭЗЯ гэсэн турван байгууллагын төсөв, түүний зарцуулалтын талаар хаанаас мэдээлэл авч болох вэ? Тухайн байгууллага нь миний асуултад хариулт өгөх үү?



#### **III.Ариунаа, Монголын эмэгтэйчүүдийн холбооны хэвлэл мэдээллийн ажилтан:**

-Улаан сайдаас асууя. 2004 оны батлагдсан төсөв нь их онцлогтой, ач холбогдолтой болсон гэдгийг хүн бүр зөвшөөрч байна. Төсөвт жендерийн мэдрэмжтэй дүн шинжилгээ хийх тухай төсөл СЭЗЯ дээр явагдаж байгаа. Энэ төслийн үйл ажиллагаа нь төсөвт нөлөөлсөн үү?

Ил тод байдлын талаар олон улсын жишиг ярьж байхдаа Малайз зэрэг зарим оронд олон нийтийн байгууллага нь чиглэл чиглэлээрээ Засгийн газартаа саналаа илэрхийлдэг тухай ярьсан. Энэ маягаар манайд ажиллавал нээлттэй гэж Та хэлсэн. Иргэний нийгмийн байгууллагууд жил жилээрээ төсөвт өөрсдийн дүн шинжилгээг хийгдээд Засгийн газарт мэдээлэх боломж байгаа гэсэн үг үү?



#### **Санал : Н.Бямба, Өвөрхангай аймгийн Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн ходолгооний салбар зөвлөлийн зохицуулагч:**

1. Манай байгууллага 1998 оноос хойш орон нутгийн төсөвт иргэдийн оролцоог сайжруулах талаар тогтмол үйл ажиллагаа явуулж тодорхой амжилтад хүрч байгаа юм. Энэ талаар санал хэлмээр байна. Бид энэ үйл ажиллагааг эхлээд судалгаа явуулж, дараа нь Соросын сангийн санхүүжилттайгаар 9000 хувиар хэвлэгддэг “Гурвалжин мэдээ” сонинг гаргах болсон. Сонинд орон нутгийн төсвийг нээлттэй болгох тухай мэдээлдэг бөгөөд нийт 12 дугаарт төсвийн талаар нийтлэгдээд байгаа. Бидэнд энэ талаарх мэдээллийг олж авахад ямар нэг бэрхшээл, хэцүү асуудал байдагтүй. Улсын төсвөөс өгсөн мөнгөний дүнг сониндоо бичсэнээр илүү нээлттэй болдог. Дутагдалтай нэг тал бий. Улаан сайдад хэрэг болох нэг санал хэлэх гээд байна л даа. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн мөнгө гэж өгдөг. Зарим тохиолдолд нийтэд хүртээмжтэй мөнгийг бид олж авч чадахгүй, эсвэл нуучихдаг ч юм уу тийм тохиолдол гардаг. Нийт хүн амд хэрэгтэй мөнгөний талаарх мэдээллийг вэб сайт гаргаад байрлуулчихвал бид түүнийг сониндоо мэдээлснээр давхар хяналттай болох ач холбогдолтой юм.

2. ИТХ-аар төсвийг хэлэлцүүлдэг гэж ярьж байна. Энэ нь нэгэнт хуулинд баталсан учраас л ингэж явж байгаа байх. Манай Үндсэн Хууль төвлөрлийг сааруулна, иргэдийг идэвхтэй оролцуулж байж хөгжилд хүрнэ гэж заасан боловч удирдлага санхүүжилтийн хууль нь төвлөрүүлчихсэн байгаа. Энэ утгаараа эдийн засгийн үр ашгийн үүднээс авч үзэхэд иргэдийг идэвхтэй оролцуулна гэчихээд оролцуулахгүй байгаа нь сөрөг талтай юм биш үү.



## Ч.Улаан, Санхүү Эдийн Засгийн Сайд:

Хоёрдугаар эмнэлэг, СЭЗЯ-ы төсвийн гүйцэтгэлийг хаанаас авч болох вэ? гэсэн Сайнзаяагийн асуултад хариулья.

Тухайн байгууллага дээр очиж үзэж болно. Хэрэв манай СЭЗЯ-ны төсвийн тайланг үзье гэвэл бид нээлттэй. Бусад төсөв захирагч нарт бид мөн тийм л шаардлага, чиглэлийг өгч байгаа.

Вэб сайтдаа сангудынхаа үйл ажиллагааны байдлыг тавьж болдоггүй юм уу гэж Бямбаагийн хэлсэн үгэнд хөндөгдлөө. Тэр зүйтэй, тавьж болно. Онөөдөр манайд 26 төрлийн сан байгаа. Хэдий хэмжээний орлого олсон, юунд зарсан гэдэг нь ил тод байх ёстой. Энэ талаар бид төсвийн захирагч нартаа тодорхой чиглэл өгсөн. Тийм учраас үүнийг цаашдаа хэвшил болгох нь зүйтэй юм. Энэ талаар хамтарч ажиллья. Тэр 26 сан чинь бүгдээрээ миний мэдлийнх биш. Миний мэдэлд:

- Засгийн газрын нөөц хөрөнгө,
- Засгийн газрын хуваарилагдаагүй зардал,
- Болзошгүй эрсдэлийн сан байdag. Эдгээрийн талаарх мэдээллийг вэб сайгад тавихад би бэлэн байна.

Ариунаагийн асуулт байна. Жендерийн мэдрэмжтэй төсөл манай яам дээр хэрэгжиж эхэлсэн. Бид судалгаа хийж, тодорхой төрлийн саналууд боловсруулж байна. Яг энэ чиглэлээр бие даалгаад төсөлд тусгасан гэдэг асуудлыг өнөөдөр хэлэхэд бэрхшээлтэй байна. Ер нь аль болохоор төсвийн хэрэгжилтэд жендерийн мэдрэмжийг дээшлүүлэх чиглэлээр судалгаа шинжилгээ хийж, дүгнэлт гарган ажиллаж хэлж байна. Энэ бол эхний алхам юм. Иргэний аль ч нийгэмлэг, байгууллага нь судалгаа хийгээд дүгнэлтээ гаргаад саналаа өгвэл төсөв хянах явцад харгалзан үзэх бүрэн бололцоотой. Маш олон төрлийн санал гардаг. Тэр бүгдийг төсөвт бүрэн хэмжээгээр тусгаж чадахгүй гэдгийг ойлгох хэрэгтэй. Ямар нэг хэмжээнд хянаж бодлогод уялдуулах асуудал гардаг. Онөөдөр бидний хувьд тийлийлийн ардчиллын зарчмаар төсвөө хэлэлцдэг түгээмэл арга хэвшсэн байна. ИТХ-аар, УИХ-аар төсвөө нээлтэй хэлэлцдэг. Энэ төлөөллийн зарчмаар дамжуулаад ард иргэд төсөв хэлэлцэхэд өргөн оролцож байгаа гэж бодож байна. Мөн үүний зэрэгцээ иргэдийн шууд оролцоо, иргэний нийгэмлэгээр дамжуулан оролцох асуудалд ач холбогдол өгч энэ журмыг хэрэгжүүлэх ёстой гэдэгтэй санал нэг байгаа. Яг төрийн бодлого тодорхойлогдох, батлагдахаа төлөөллийн ардчиллын зарчмаар явж байгаа гэдгийг та бүхэн ойлгож байгаа.



## Хөтлөгч : Д. ЭНХБАТ

Манай асуулт, хариултын цаг дууслаа. Үйл ажиллагааныхаа төгсгөлд панелд оролцсон төлөөлөгчдөөсөө энэ ярилцлагын талаар асууя.



## Саха Мяянатан, Дэлхийн банкны суурин төлөөлөгч:

Ийм ярилцлагыг анх удаа зохион байгуулж байгаа тул тодорхойлж хэлж мэдэхгүй. Анхны оролдлогыг хийж үзлээ. Цаашид ямар байдлаар хэрэгжүүлэх тухайд бүгд анхаарч тэвчээртэй ажиллах байх. Та бүхэн Сорос болон бусад энэ чиглэлийн байгууллагаас мэдээлэл авах боломжтой. Ийм ажлыг зохион байгуулахад тодорхой хэмжээний цаг хугацаа шаардагддаг бөгөөд энэ арга хэмжээ тогтмолжих хүртэл та бүгдийн оролцоо чухал.

Юуны өмнө энэ ярилцлагыг зохион байгуулж байгаа Сорос сангийн удирдлагад талархлаа илэрхийлж байна. Хандивлагчдын төлөөлөгчдийн нэрийн өмнөөс болон Улаан сайд бид хоёрын өмнөөс хатагтай Эрдэнэжаргал, ноён Энхбат нарт бид бүхний ярилцахыг хүсэж байсан сэдвээр өөрсдийнхөө санал болдлыг хуваалцах боломж олгосонд баярласнаа илэрхийлье. Ийм арга хэмжээг цаашид олон сэдвээр үргэлжлүүлнэ гэдэгт найдаж байна.

Нөгөө талаар төсөв гэдэг бол маш чухал ач холбогдолтой үйл явц юм. Төсөв өөрөө чухал баримт бичиг. Төсвийн боловсруулалт, хэрэгжилт, хяналт, аудитийн гээд олон аспект байдаг. Эдгээрийг хэрэгжүүлж авч явахын тулд өнөөдөр дэмжлэг туслалцаа үзүүлж байгаа Засгийн газарт ч, Соросын санд ч талархлаа илэрхийлэх хэрэгтэй байх. Бид ийм маягийн арга хэмжээг цаашид дэмжинэ гэдгээ илэрхийлж байна.



### Доун Рэм, Олон Улсын Валютын Сангийн суурин тыйлийлжч:

-Би Дэлхийн банкны түншийнхээ хэлсэн үгийг дэмжиж байна. Онөөгийн нөхцөлд өндөр хөгжилтэй орнууд ч ил тод байдлыг хэмжих шалгууруудыг түгс боловсруулж чадаагүй байна. Иймээс ил тод байдлын үзүүлэлт нь хэр зэрэг ахиулж чадаж байна гэдгээр л хэмжигдэг бөгөөд энэ нь олон нийтийн анхаарлыг татсан асуудал юм. Энэхүү олон нийтийн анхаарлыг татах нэгэн арга хэмжээ болох өнөөдрийн уулзалт ярилцлагыг зохион байгуулагчдад талархлаа илэрхийлэх нь зүйтэй болов уу. Энэ төрлийн ажил цаг хугацаа шаардсан нарийн төвөгтэй асуудал байдал юм.



### Ч.Улаан, Санхүү Эдийн Засгийн Сайд:

-Онөөдрийн энэ ярилцлагыг зөв зүйтэй арга хэмжээ болж байна гэж би бодож байна. Цаашдаа иймэрхүү ярилцлагыг тогтмол зохион байгуулж байх нь үр дүнтэй. Улс орны эрх ашиг, хөгжил дэвшлийн аливаа асуудлаар өргөн хүрээнд, тодорхой нэг сэдвээр харилцан мэдээллээ солилцох нь ашигтай. Жишээ нь, дараагийн нэг сэдэв нь төсвийн зардлыг яаж хорогдуулах вэ, эсвэл дотоодын зээллэгийг хэрхэн оновчтой зохион байгуулах вэ гэх мэт төрөлжсөн сэдвээр ярилцвал нь илүү үр дүнтэй болох байх. Ингэж уулзаж ярилцах нь нэг талаар харилцан бис биедээ мэдээлэл өгөх, ногөө талаар бие бисийнхээ зарим нэг эргэлзээг тайлж байна. Эргэлзээ тайлагдана гэдэг нь хардах сэрдэх байдал арилна гэсэн үг.

Та бүхэн энэ удаагийн ярилцлагыг зохион байгуулсан шиг дараагийн ярилцлагад оролцооч, тодорхой сэдвээр мэдээлэл өгөөч гэвэл бид байнга бэлэн байна. Энд хүрэцэн ирж анхааралтай сонсож, санал бодлоо харамгүй хэлсэн. Та бүхэнд талархаж байгаагаа илэрхийлье. Энэ бол зөвхөн миний байр суурь биш, би хоёр илтгэгчийг төлөөлж хэлсэн юм шүү.



### Хөтлогч Д.Энхбат:

Бидний зохион байгуулж байгаа ярилцлага нь харьцангуй чөлөөтэй. Ерөнхий дэг нь ярилцлага байсан. Сонссон биш асуусан шүү дээ. Зарим хүн санал хэлсэн. Ганц нэг асуулт хариулагдаагүй үлдчих шиг болсон. Гэхдээ би үүнийг маш олон уулзалтын нэг хэсэг гэж бодож байна. Тийм учраас бид үргэлжлүүлээд ярина. Онөөдөр бүх юмыг шийддэг зүйл бол цаг. Тиймээс бид цагаа барих хэрэгтэй.

Эцэст нь хэлэхэд энд оролцсон хүмүүст талархлаа. Ялангуяа илтгэгчид, асуулт асуугчид, уулзалтыг зохион байгуулагчдад баярлалаа. Ярилцлагын тийгсийлд би өөрийнхөө дүгнэлтийг хэль. Энэ уулзалтын гол санаа нь бие бисэ сонсох явдал. Тэрчлэн хамгийн чухал зүйл болох Засгийн газар, олон нийтийн байгууллага, иргэд, манайд тусалж байгаа донор орнууд бидний өмнө тулгарч байгаа асуудлыг хамтарч шийдэх тухай яригдана. Тэгэхээр та бүгдийн хамтын ажиллагаа цаашид үргэлжилнэ гэдэгт найдаж байна. Ингээд та бүхэнд энэ ажиллагаанд оролцсонд их баярлалаа.



### Д.Жаргалсайхан, МННХ-ийн Удирдах зөвлөлийн гишүүн:

Соросын сангийн Удирдах зөвлөлийн өмнөөс энэ ярилцлагыг хааж үг хэлье. Монгол Улсын төсвийн зарлага талыг Монгол хүмүүсийн нүүр царай, орлого талыг Монголын нүүр царай гэж ярьдаг болсон байна. Монголын хүн амын орлогын албан татвар манай нийт төсвийн таван хувиас бага байдаг. Гэтэл энэ төсвийн таваас илүү хувь нь гадаадын байгууллагуудаас авсан зээл тусламжаас бүрддэг. Энэ нь манай төсвийн орлого нь гадаадын нүүр царайтай гэсэн үг юм. Бид ийм ярилцлагыг олон удаа хийсний үр дунд Монгол хүмүүсийн нүүр царайтай орлоготой төсөвтэй болвол түүнд мөнгөө төлж байгаа хүмүүс жинхэнэ төсвийн зарцуулалтад оролцогч болох юм. Эцэст нь хэлэхэд хүн амын орлогын албан татвар таван хувь байгаа, имчийн татвар гэж байдагтүй юм байна. Нэг үеэ бодвол нийгэмд ялгарал гарч, мөнгөтэй, газартай, байшинтай боломжтой хүмүүс бий болжээ. Тэднээсээ татвар авсан ийм сайхан төсөвтэй болохын төлөө чин эрмэлзэл бүтэх болтугай.